



“ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД ХИЛИЙН БООМТЫГ
ТӨМӨР ЗАМААР ХОЛБОХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ

АГУУЛГА

БҮЛЭГ 1. Төслийн танилцуулга.....	1
БҮЛЭГ 2. Төслийн талбай, түүний байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	2
2.1. Төслийн талбайн байршил.....	2
2.2. Нийгэм-эдийн засгийн ерөнхий төлөв.....	2
БҮЛЭГ 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлийн товч тодорхойлолт.....	3
3.1. Агаарын чанар.....	3
3.2. Дуу шуугиан.....	3
3.3. Гадаргын болон газрын доорх ус.....	3
3.4. Газрын гадарга хэвлий.....	3
3.5. Ургамлан нөмрөг.....	4
3.6. Амьтны аймаг.....	4
3.7. Тусгай хамгаалалттай газар нутаг.....	5
3.8. Хаягдлын менежмент.....	5
БҮЛЭГ 4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	6
4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	6
БҮЛЭГ 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	7
БҮЛЭГ 6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	10
БҮЛЭГ 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	11
БҮЛЭГ 8. Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө.....	12
БҮЛЭГ 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	14
БҮЛЭГ 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	15

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Товч танилцуулга

Монгол Улсын Их Хурлын 2023 оны “1955 оны Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолоор Хилийн боомт дахь ачаа тээврийн урсгалыг сайжруулах, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхийг Засгийн газарт даалгасан.


Энэхүү тогтоолын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 310, Зам, тээврийн сайдын 2025 оны 01 дугаартай албан даалгавраар төслийн ажлыг эрчимжүүлсэн. Мөн “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг Тавантолгой төмөр зам ХХК-д 5-н жилийн хугацаатай олгосон.

“Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан төмөр замын төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын үргэлжлэл бөгөөд нийт 7 багц ажлаас бүрдэнэ. Үүнд :

- Багц 1. Дээд, доод бүтэц
- Багц 2. Урт гүүр (эстакад)
- Багц 3. Эрчим хүч;
- Багц 4. Барилга байгууламж
- Багц 5 Холбоо дохиолол
- Багц 6. Авто зам
- Багц 7. Гааль, хилийн хяналтын тоног төхөөрөмж

Энэхүү төслийн төмөр зам нь 1-р зэрэглэлийн, 1520 мм өргөн царигийн замын урт 10.801км, 1435 мм нарийн царигийн хос замын урт 8.697км, нийт гол замын урт 19,5 км, нийт гүүрний урт 9.35 км ба нийт трассын 48%-ийг эзэлж байна. Мөн техникийн үзүүлэлт, гадаргын хотгор гүдгэрээс шалтгаалан 31 м өндөр суурь бүтэцтэй төмөр зам баригдах нөхцөл үүссэн. Өргөн царигаар жилд 30 сая.тн, нарийн царигаар жилд 10 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай болно. Тус төмөр зам нь 3 гүүр, 28 ус зайлуулах хоолойтой байхаар төлөвлөгдсөн.

Зураг-1. Төмөр замын ерөнхий төлөвлөлтийн зураг



Тавантолгой төмөр зам ХХК нь “Гашуунсухайт-Ганцмод” хилийн боомтыг төмөр замаар холбох төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг 2024 оны 04 дүгээр сард байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар хянан батлуулсан.


Тус төслийн барилга угсралтын ажлын явцад хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ), Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ. БОХТ буюу сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийг нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан. ОХШХ-т нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, хяналт-шинжилгээ хийх цэгийн байршил, хугацаа ба давтамж, баримтлах стандарт, арга аргачлал болон шаардагдах зардал зэргийг тодорхойлон оруулсан.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн талбайн байршил

“Тавантолгой төмөр зам” ХХК-ний хэрэгжүүлэх “Гашуунсухайт-Ганцмод” хилийн боомтыг төмөр замаар холбох төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт хэрэгжих бөгөөд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг БНХАУ-ын Ганцмод-Ваншуйчуань чиглэлийн төмөр замтай холбоно.

Зураг-2. Төслийн талбайн байршлын зураг



2.2. Нийгэм, эдийн засгийн ерөнхий төлөв

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь Өмнөговь бүс нутгийн томоохон стратегийн ач холбогдол бүхий хөгжлийг тодорхойлох сум юм. Өмнөговь аймгаас 295км, Улаанбаатар хотоос 779км алслагдсан хэдий ч засмал замаар бүрэн холбогдсон давуу талтай.

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь Монгол улсын өмнөд хэсэгт 15,150 мян.км² газар нутгийг эзлэх бөгөөд урд хэсгээрээ БНХАУ-тай, баруун хэсгээрээ Баян-Овоо, хойд хэсгээрээ Мандах, зүүн хэсгээрээ Дорноговь аймгийн Хатанбулаг зэрэг сумдтай хил залгаа оршино. Ханбогд сум нь Номгон, Гавилууд, Жавхлант, Баян, Хайрхан гэсэн багуудтай ба Гашуунсухайт-Ганцмод” хилийн боомтын төсөл нь Хайрхан багийн нутагт хэрэгжинэ.

Төсөл хэрэгжих газар нутаг нь Говийн бага дархан цаазат газрын Б хэсгийн хязгаарлалтын бүсэд хамаарах тул хүн ам, мал аж ахуй харьцангуй бага юм.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжүүлэх “Гашуунсухайт-Ганцмод” хилийн боомтыг төмөр замаар холбох төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслийн гол нөлөөллийг үнэлэн тогтоов. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, БОНХЯ-аас гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний аргачилсан заавар /2014/, байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг матриц, магадлан жагсаах, давхцуулан зураглах, загварчлалын арга, харьцуулсан судалгаа, экспертийн үнэлгээний арга зэргийг ашиглан хийж тодорхойлов.

3.1. Агаарын чанар. Төслийн үйл ажиллагааны улмаас хөрс эвдэгдэн тоосрох, хүнд даацын автомашины хөдөлгөөн, газар шорооны ажлын үед тоос босохоос гадна автомашин механизмын яндангаас гарах хорт хийн хаягдал нь агаарын чанарт нөлөөлж болзошгүй. бохирдуулах бодисын агууламжийг бага зэрэг ихэсгэнэ. Нөлөөллийн эрчмийн хувьд технологийн үе шатуудад дунд болон бага зэрэг сөрөг нөлөөлөлтэй байхаар үнэлсэн.

3.2. Дуу шуугиан. Дуу чимээний түвшин нь тээвэрлэлтийн бүхий л үйл ажиллагаа, карьер ажиллуулах, чулуу бутлах, төмөр замын далан байгуулах ажиллагааны үе дэх шуугианы нөлөөллийн эрчим бага ба дунд зэрэг байхаар үнэлсэн. Энэ нь хүнд даацын автомашинуудын хөдөлгөөний үед үүсэх дуу шуугиан, уурхайн ухах, ачих механизмууд, бутлагч, замын барилгын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллагааны үеийн шуугианы нөлөөлөлтэй холбоотой. Эдгээрээс үүссэн шуугиан нь тухайн орчныхоо шуугианы түвшнийг нэмэгдүүлж, тэр нь төслийн ажиллагсад болон төслийн талбай орчмын иргэдэд сөргөөр нөлөөлнө.

3.3. Гадаргын болон газрын доорх ус. Усны сав газрын хувьд Галба-Өөш-Долоодын говийн савд төслийн талбай оршино. Төмөр замын барилгын материал, техникийн нөхцөлийн хувьд хэвийн бус хүнд даацын машин механизм, автомашинуудын эд ангиас тос, тосолгооны материалууд асгарч болзошгүй бөгөөд энэ тохиолдолд хур тунадас болон үерийн усаар угаагдан голдирлуудын хурдсыг бохирдуулах, улмаар ил задгай устай нийлж гадаргын усыг бохирдуулах зэрэг сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй.

3.4. Газрын гадарга, хэвлий. Төмөр замын трасс орчимд цөлийн бор саарал хөрс зонхилон тархаж байгаа учраас төмөр замын трасс барих явцад хүнд даацын автомашин, механизмын хөдөлгөөний улмаас хөрсний эвдрэл нэмэгдэж, хөрс элсжих, хөрс бохирдох, агаарт тоосжилт үүсэх сөрөг нөлөөлөл бий болох ба нөлөөллийн эрчимжил харьцангуй бага байна.

Эдгээр сөрөг нөлөөллийн цар хүрээ нь хийгдэх ажлын хэмжээ, технологийн горим, зохион байгуулалт, байгаль орчны дүрэм журмын биелэлт, хяналт, аюулгүй ажиллагааны дүрэм, ажилчдын хянуур болгоомжтой байдал зэргээс хамаарна. Барьж байгуулах үе шатанд үүсэх хөрсөн бүрхэвчийн доройтол, элэгдэл, эвдрэл үүсэж болзошгүй.


3.5. Ургамлан нөмрөг. Төмөр замын барих үеийн хөрс хуулалтаар ургамлан нөмрөг устах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтын улмаас ургамлын фотосинтезийн эрчим буурах зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй. Бүтээн байгуулалтын ажил дуусгавар болж төмөр зам ашиглалтад орсноор хөрс, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл буурна.

3.6. Амьтны аймаг. Төсөл хэрэгжиж буй нутгийн тууртан амьтад болох хулан, хар сүүлт нь ургамлын гарц, байгаль цаг уурын тааламжгүй нөхцөл, усны хэрэгцээ шаардлагаас улбаалан уудам орон зайд шилжилт хөдөлгөөн хийдэг. Тиймээс аливаа шугаман дэд бүтэц ялангуяа төмөр замаас шалтгаалан шилжилт хөдөлгөөн хийх боломж нь хумигдах үед тухайн амьтдын тоо толгойд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдэнэ.

Зураг-3. Ан амьтны шилжилт хөдөлгөөний байршил ба гүүрийн трасс




Зураг-4. Гүүрийн хийцлэлийн зураг



3.7. Тусгай хамгаалалттай газар нутаг. Төслийн талбай нь Говийн бага дархан цаазат газрын Б хэсгийн хязгаарлалтын бүсэд хэрэгжих байгаа бөгөөд төлөвлөж буй төмөр замын трасс нь “Аймгийн урд талын сумдын улсын хил дагуу” нэртэй /аймгийн/ орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай 3.3км хэсэгчилсэн давхцалтай байна.

Зураг-5. УТХГ-ын хилийн заагийн зураг



3.8. Хог хаягдлын менежмент. Түр кемп, төслийн талбай, карьерын орчимд ажиллаж буй ерөнхий болон туслан гүйцэтгэгч нарын үйл ажиллагаанаас ахуйн болон аюултай хог хаягдлууд үүснэ. Энэ нь санамсар болгоомжгүй байдлаас шалтгаалан асгарч алдагдсанаа

болж хүрээлэн буй орчныг бохирдуулж болзошгүй. Төмөр замын барилга, байгууламжуудын үйл ажиллагааны үед бий болох хаягдал, тэдгээрийн устгал, зайлуулалтын улмаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг хог хаягдлын менежментийн техникуудийг шинээр тусган хэрэгжүүлэх замаар хог хаягдлын менежментийг хэрэгжүүлнэ.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжих төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурлан боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Тус төслийг хэрэгжүүлэх 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах зүйлсээс бүрдэх бөгөөд нийт зардал 10,256,000 (арван сая хоёр зуун тавин зургаан мянган) төгрөг. Үүнд:

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
5. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө

д/д	Авах арга хэмжээний нэр	Зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,100,000.0
2	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	920,000.0
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,960,000.0
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,476,000.0
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	800,000.0

6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	-
	Нэг жилийн нийт зардал, төгрөг	10,256,000.0

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг Монгол Улсын Байгаль орчны багц хуулиудаар тавигдсан шаардлага, БОАЖЯ-ны 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, БОННҮ-ний хүрээнд боловсруулсан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, шаардлагуудыг үндэслэн тодорхойлов.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
1. АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Төслийн ажилд ашиглагдах машин механизмаас ялгаран гарах хорт хий орчны агаарыг бохирдуулах	Техник хэрэгслийг үзлэг оношлогоо, засвар үйлчилгээг тогтмол хийж, стандарт шаардлагад нийцүүлэх	Төслийн талбай ашиглаж буй машин механикм, техник хэрэгсэл	ш	-	Үйл ажиллагааны зардлаас		2025 он	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага
Барилгын ажлын талбай болон шороон замаас тоос дэгдэж хүрээлэн буй орчинд тархах, агаарын чанарт нөлөөлөх	Төслийн тоосжилт үүсэх зам, талбайг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах,	Төслийн ажилд ашиглаж буй бүх зам талбай	м3	-	Үйл ажиллагааны зардлаас		2025 онд	
Дүн						-		
2. УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Усыг тооцоогүй ашигласнаас газрын доорх усны нөөц хомсдох	Барилга угсралтын ажлын явцад усны эх үүсвэрүүдийг тоолууржуулах	Гүний худгууд	ш	4	465,000	1,860,000		Усны тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн

Усыг их хэмжээгээр ашигласнаас үүдэн усны ундарга муудах, түвшин буурах	Төслийн ажилд ашиглаж буй худгуудад хэмжилт хийх	Гүний худгууд	ш	4	-	-	/улиралд 1 удаа, нийт 12/	сайдын 2013 оны А/156 “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
Дүн						1,860,000		
3. ХӨРС БА УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР								
Үржил шимт хөрс, ургамлан бүрхэвч бүхий талбай барилга байгууламж, машин механикмын үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэж ургамлан бүрхэвч сөрөг нөлөөлөлд өртөх	Төслийн ажлын явцад түр замын маршрутыг тогтоож, олон салаа зам үүсгэхгүй байх, тэмдэгжүүлэх,	Барилгын ажлын талбай /кемп, карьер, худаг г.м/	ш	10	80	800,000	2025 онд	Газрын тухай хууль
	Барилгын ажлын явцад өртөж болзошгүй талбайн шимт хөрсийг хуулж хадгалах,	Барилгын ажлын талбай /карьер, төмөр замын трасс, барилга, түр зам/	м2		Үйл ажиллагааны зардлаас		2025 онд	MNS 5916:2008 “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”
Дүн						800,000		
НИЙТ ЗАРДАЛ						2,660,000		

БҮЛЭГ 6. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс шалтгаалан болзошгүй осол, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл гарах, үйл ажиллагаа доголдох, зогсох,	Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг мэргэжлийн байгууллагас авч үйл ажиллагаанд тогтмол ашиглах	Төслийн талбай	сараар	12	40,000	480,000		Ус цаг уур орчны хяналт шинжилгээний тухай хууль
Болзошгүй осол, техник, тоног төхөөрөмжийн гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Төслийн нийт инженер, техникийн ажилчид	удаа	2	-	-	Жилдээ 2-оос доошгүй удаа	Галын аюулгүй байдлын тухай хууль
	Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангах	Төслийн талбай	ш	5	88,000	440,000		
						920,000		
Нийт дүн						920,000		

БҮЛЭГ 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн цар хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Ахуйн хаягдлыг ангилах, дахин ашиглах, цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн талбай	Сард	330,000	12 удаа	3,960,000	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль, холбогдох журам, заалтууд БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний Өдрийн А/445 дугаар тушаал БОАЖС-ын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 дугаар тушаал БОАЖЯ-ын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/18 тушаал
Аюултай	Хаягдал дугуй, ажилласан тос болон төмрийн хаягдлыг ангилан хадгалах дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлох	Төслийн талбай	Улирал	Хэрэглээний хэмжээгээр	Улирал 1		Ажил гүйцэтгэх гэрээний дагуу тухай бүр	
	Тээвэрлэх үйлчилгээний хөлс			-	-	-		
						3,960,000		
Нийт дүн						3,960,000		

БҮЛЭГ 8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР							
SO ₂ , CO ₂ , NO ₂ , утааны хэм °C, утааны агаарын даралт, утааны хурд м/с	Агаар-1 42°28'24.068 107°31'07.778	8 сард	Жилд 1 удаа	60,000	180,000	Төсөл эхлэх цаг хугацаанаас хамаарч давтамжийн тоо өөрчлөгдөж болзошгүй	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугиан норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. MNS ISO 226:2003 Дуу чимээ-хэвийн норм, түвшиний хэмжээ
Тоосны хэмжилт: PM ₁₀ , PM _{2.5} , тоосны чөлөөт уналт, тоосны найрлага, бүтэц, тархалт	Агаар-2 42°26'33.98 107°32'35.235 Агаар-3 42°25'22.388 107°34'41.884	8 сард					
2. УСНЫ ХЯНАЛТ							
Усны ерөнхий шинжилгээ (амт, үнэр, өнгө, рН, нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чанар, усны түвшин)	Худаг-1 42°39'37.000 107°08'42.150 Худаг-2 42°29'49.200 107°26'52.300	2, 3, 4-р улирал	3 удаа	46,000	276,000	(2 цэгээс 3 удаа, нийт 6 дээж)	Усны тухай хууль, MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
3. ХӨРСНИЙ БОХИРДОЛ							

Хөрсний ерөнхий шинжилгээ	Хөрс-1 42°28'45.635 107°31'36.705	6, 8 сард	Жилд 2 удаа	26,000	260,000	5 цэгээс 2 удаа, нийт 10 дээж авч шинжилгээнд хамруулна	MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Хүнд металлын шинжилгээ	Хөрс-2 42°27'29.176 107°30'55.903	6, 8 сард	Жилд 2 удаа	26,000	260,000		
	Хөрс-3 42°26'58.088 107°32'13.966						
	Хөрс-4 42°26'08.246 107°33'05.136	6, 8 сард	Жилд 2 удаа	26,000	260,000		
	Хөрс-5 42°29'49.200 107°26'52.300						
4. УРГАМЛАН НӨМРӨГ							
Ургамлын зүйлийн бүрдэл, Бодгалийн тоо, дундаж өндөр, Бүрхэц	Цэг-1 42°26'39.769 107°31'27.773	6 сард	Жилд 1 удаа	1,500,000	1,500,000		Ургамлын тухай хууль
	Цэг-2 42°25'05.839 107°35'16.973						
НИЙТ ЗАРДАЛ				2,476,000			

**БҮЛЭГ 9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Хариуцах эзэн
	2	3	4	5	6
1	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд ажиллаж байгаа инженер, техникийн ажилчид	800,000	Тухай бүрт	ХЭМАБ-ын хэлтэс, бусад газар, хэлтэс
2	Байгаль орчны хамгаалах талаар сургалтыг зохион байгуулах, орон нутгийн байгаль орчны албатай харилцан холбоотой ажиллах			2-оос доошгүй удаа	ТХГ, Байгаль орчин, орон нутгийн хэлтэс
3	Ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Гэрээт байгууллагаар хийлгэх	-	Жилд 1-ээс доошгүй	ЗУГ, Захиргаа, эрхзүйн хэлтэс /Эмч/
			800,000		
НИЙТ ЗАРДАЛ			800,000		

**БҮЛЭГ 10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН
БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах, хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Багийн Иргэдийн нийтийн хурал	Уулзалт, хэлэлцүүлэг, албан бичиг	БОМТ болон түүний хэрэгжилтийг тайлагнах	11-р сар	-	Орон нутгийн мэргэжилтэн	Харъяа сум,багийн төв
Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Уулзалт, хэлэлцүүлэг, албан бичиг	БОМТ болон түүний хэрэгжилтийг тайлагнах	11-р сар	-	Орон нутгийн мэргэжилтэн	Харъяа сум,багийн төв
Аймгийн Байгаль орчны газар	Тухайн жилийн БОМТ-ний тайлан хүргүүлэх	БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах	11-р сар	-	Байгаль орчин, орон нутгийн хэлтсийн дарга, Орон нутгийн мэргэжилтэн	Өмнөговь аймгийн БОГ-т хүргүүлэх,
ДҮН				-		
Нийт дүн						